МЭДЭЭ · 2024 оны 1-р сарын 23

2023 ОНД ЖОЛООЧ ДААТГАЛГҮЙГЭЭР ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОХ ЗӨРЧЛИЙН ГАРАЛТ НЭМЭГДЖЭЭ




Улсын хэмжээнд 2023 онд 3.185.868 зөрчлийн хэрэг бүртгэгдсэн нь 2022 оны мөн үеэс 18 хувиар өссөн байна.

Нийт зөрчлийн хэргийн 72 хувь нь Нийслэлд, 28 хувь нь орон нутагт гарсан бол дийлэнх буюу 88 хувь нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил байна.

2023 онд жолооч даатгалгүйгээр замын хөдөлгөөнд оролцох зөрчлийн гаралт хамгийн их хувиар нэмэгдсэн. Тодруулбал, Жолоочийн даатгалын тухай хууль зөрчих зөрчил 56.093 бүртгэгдэж 59 хувиар, Автотээврийн тухай хууль зөрчих зөрчил 82.715 бүртгэгдэж 10 хувиар, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил 2.824.162 бүртгэгдэж 7 хувиар, Хүний биед халдах зөрчил 19.942 бүртгэгдэж 0.5 хувиар тус тус өсжээ.

Харин Олон нийтийн газар зүй бусаар биеэ авч явах зөрчил 2022 онд 112.173 бүртгэгдэж байсан бол 2023 онд 103.829 бүртгэгдэж, 7.4 хувиар буурсан байна.



Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1423